СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 оны 12 дүгээр сарын мэдээлэл

2022.12.23. “Овоот”

**Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР.**

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит XI хуралдаан 2022 оны 12 дугаар сарын 19 нд хуралдлаа. Хэлэлцсэн асуудал:

1. Сумын ИТХ-ын 2022 оны үйл ажиллагааны тайлан
2. Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтийг дүгнэх
3. 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл
4. Сумын 2021 оны төсвийн гүйцэтгэл, 2023 оны төсвийн төсөл батлах тухай
5. Сумын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл батлах тухай
6. “Дарьганга тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ ын тайлан
7. Бусад асуудал хэлэлцэх .

-ИТХ-ын үр дүнгээр сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд төлөөлөгчдийн 100% ийн саналаар “Хангалттай” гэсэн үнэлгээг өгөв.

-2023 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,130,384.2 мянган төгрөгөөр баталлаа.

**-Хууль эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын чиглэлээр**

“БИЗНЕСЭЭ АМЖИЛТТАЙ УДИРДАХУЙ” сэдэвт 3 цагийн сургалтыг сумын Төрийн банк хариуцан зохион байгуулж төрийн болон аж ахуйн нэгжийн төлөөлөл 15 хүн оролцож, сургалтын үр дүнгээр 15 иргэн “Өрхийн төсөв”-өө бүртгэх болон манлайлал, маркетингийн талаар ойлголттой болсон.

“Бяцхан үрс өвдөхгүй” аяныг аймгийн Хөдөлмөр халамжи үйлчилгээний газраас зарлаж, уг аянд нэгдэн зорилтот өрхийн 0-5 насны 18 хүүхдэд ЗДТГ, Цэцэрлэг, 3 аж ахуйн нэгж нийт 5 байгууллагаас 1,215000 ( нэг сая хоёр зуун арван таван мянган) төгрөгийн эд материалын дэмжлэг үзүүллээ.

**Хоёр. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР**

2022 оны жилийн эцсийн мал тэжээвэр амьтдын тооллогыг хуулийн хугацаанд зохион байгуулж, үр дүнд нь урьдчилсан байдлаар сумын мал 5 төрөл дээрээ, хүн ам өссөн үзүүлэлттэй байна.

**Гурав. СОЁЛ, БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР**

"ДАРЬГАНГАД ӨРГӨХ ДУУЛАЛ" сэдэвт Дарьгангын яруу найргийн сургуулийг үндэслэгч Нэрт яруу найрагч, орчуулагч Доржийн ГОМБОЖАВЫН мэндэлсний 90 нас , түүний залгамжлагчид болох Д.Нямсүрэн (75 нас), Г.Мэнд- Ооёо (70 нас), О.Дашбалбар (65 нас) нарын ойд хамтатган зориулж тал нутгийн яруу найрагчдын уулзалт боллоо. Уулзалтад хэл бичгийн ухааны доктор, яруу найрагч Б.Магсаржав, Чингис хаан одонт зохиолч, яруу найрагч Г.Мэнд-Ооёо, Соёлын гавьяат зүтгэлтэн,

яруу найрагч Н.Лутбаяр, Утга зохиол судлаач, докторант О.Мөнхнаран, Соёлын гавьяат зүтгэлтэн яруу найрагч Ай.Төмөр-Очир, С.Амартайван, мөн нэрт яруу найрагч Д.Гомбожав, Д.Нямсүрэн, О.Дашбалбар нарын гэр бүл, үр хүүхэд, ах дүү, төрөл төрөгсөд оролцов.

2022.12.09-10-ны өдрүүдэд Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль дээр 12 “а” ангийн суралцагчид, 7 багшийн хамт туршлага судлан хамтран ажиллалаа.

Сумын ЕБС-ийн багш, ажилчид Дорнод аймгийн 4 сургуулийн үйл ажиллагаа, сургалттай танилцаж, туршлага судаллаа.

“ХУН” хүүхдийн урлагийн бага наадамд 20 суралцагч оролцож хүрэл медаль хүртсэн бөгөөд шилдэг номерийн тоглолтыг сумандаа зохион байгууллаа.

БШУСайдын 2022 оны 11 сарын 29-ний өдрийн А/500 тоот тушаалын хүрээнд Боловсролын үнэлгээний төвөөс улсын хэмжээнд цэцэрлэгийн гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулж, амжилттай үнэлэгдсэн цэцэрлэгт гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн нэмэлт урамшуулал тооцон олгох Боловсролын Ерөнхий газрын даргын А/343 дугаар тушаалаар Дарьгангын цэцэрлэгт нэмэлт үр дүнгийн урамшуулалд **13.420.1** төгрөгийг олгосон.

**<u>Дөрөв. Эрүүл мэндийн чиглэлээр</u>**

Дэлхийн ДОХ-той тэмцэх өдрийг тохиолдуулан 9-12 дугаар ангийн сурагчдын дунд “Дэвжээ” тэмцээнийг ЭМТөвтэй хамтран зохион байгуулллаа.

ЭМТ-өөс “ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАЯ” уриан дор Дэлхийн ДОХ-той тэмцэх өдрийг тохиолдуулан тусгай хөтөлбөрт арга хэмжээг зохион байгуулж 240000 төгрөгийн шагналын сантай “Караоке” тэмцээн зохион байгуулсан.

“ДОХ-ын өнөөгийн байдал ба түүний урьдчилан сэргийлэлт” сэдвээр нийт 62 иргэнд танхимын сургалт явуулж гарын авлага , витамин , бэлгэвч түгээлээ .

-Сумын ЗДТГ, ЕБС, Цэцэрлэг, Соёлын төв зэрэг байгууллагууд ажилтан албан хаагчдаа “Эрт илрүүлэг” үзлэгт хамруулллаа. Үзлэгийн хувь 80 % тай байна.

-Аймгийн Эрүүл мэндийн газраас ажлын хэсэг сумын ЭМТ-д ажиллаж ХШҮ- гээ хийгдсэн, мөн аймгийн ЭМГ-ын “Эх хүүхдийн баг” үзлэг, сургалт сурталчилгаа хийсэн.

МЭДЭЭЛЭЛ БИЧСЭН

МЭРГЭЖИЛТЭН Д. МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН

ЗАСАГ ДАРГА Д. БОЛДБААТАР